



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/542

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмчилгээний зардал хүссэн Б.Батчулуун, А.Мөнхцэцэг, А.Нарантуяа, Г.Бямбарагчаа, А.Эрдэнэбилэг, Г.Бүжинлхам нарт тус бүр 500.000 (Таван зуун мянга), Энэрэл өрхийн эрүүл мэндийн шинэ барилгын нээлтийн арга хэмжээнд 500,000 (Таван зуун мянга) төгрөг, Бүгд найрамдах Солонгос улсаас ирсэн төлөөлөгчдийн уулзалт ярилцлага арга хэмжээнд зарцуулагдах 750,000 (Долоон зуун тавин мянга) төгрөг, үерийн голомтот эцсийн халдваргүйтгэл хийхэд зарцуулагдсан 2,000.000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 6,250.000 (Зургаан сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ